



ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ



ДАЛАЙН ЗАХИРГААНЫ 2015 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

УЛААНБААТАР ХОТ



БНСУ-ын KBS телевиз Монгол Улсын далайн салбарын өнөөгийн өнгө төрх, далайд гарах гарцыг судлан 2015 оны 02 дугаар сард баримтат кино хийн KBS телевизээр Монгол орны далайн салбарыг сурталчилсан.



Монгол Улсын Далайн захиргаа, БНСУ-ын Далайн тээвэр, Загас агнуурын институттэй байгуулсан хамтын ажиллагааны санамж бичгийн хүрээнд 2013 оноос эхлэн Монгол далайчдыг тус институтэд бэлтгэж байна.

Далайн тээвэр, загас агнуурын институт нь дотоодын болон олон улсын далайн тээвэр, загас агнуурын чиглэлээр олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хөлөг онгоцны удирлага, жолоодлого, инженерийн мэргэжлээр 1,6 жилийн хугацаанд далайчдыг бэлтгэдэг сургууль юм.



Санамж бичгийн хүрээнд тус сургуульд суралцахаар сонгогдсон 2 сонсогч БНСУ-ын Пусан хотод байрлах сургуульдаа хүрэлцэн очиж нээлтийн арга хэмжээнд оролцов. Хичээл 2015 оны 3 дугаар сарын 24-ний өдрөөс эхлэж байна.

Монгол Улсын төрийн байгууллагад ажиллах хугацаандаа гаргасан амжилт, ололт болон Далайн захиргааны хамт олныг чадварлагаар удирдан зохион байгуулж, салбарын хууль эрх зүйн орчин, гадаад харилцааг хөгжүүлэх үйлсэд гаргаж буй хичээл, зүтгэлийг үнэлэн Далайн захиргааны дарга Хуушааны Энхбаатарыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2015 оны дугаар зарлигаар "Цэргийн гавъяаны улаан тугийн одон" цол тэмдэгээр шагнасныг Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Батэрдэнэ гардуулж өгөв.



ЗАМ, ТЭЭВРИЙН САЙД Н.ТӨМӨРХҮҮ ТАНАА

Талархал

“COAL MONGOLIA” нүүрсний салбарт хөрөнгө оруулагчдын олон улсын чуулга уулзалт, үзэсгэлэн нь жил ирэх бүр олон улсад нэр хүнд нь өсч байгаа Монголын нүүрсний салбарын хамгийн том олон улсын чуулга уулзалт, үзэсгэлэн юм.

Бид энэ удаагийн “COAL MONGOLIA-2015” олон улсын чуулга уулзалт, үзэсгэлэнг “Coal Mongolia”-чуулганы 5 жилийн ой, Монголчууд гадаад зах зээл дээр анхдагч хувьцаа (IPO) гарган нүүрсний салбарт хөрөнгө оруулалт татсаны 5 жилийн ой тус тус тохиолдуулан 2015 оны 4-р сарын 9-10 өдрүүдэд Монголын Улсын Засгийн Газрын дэмжлэгтэйгээр өндөр түвшинд амжилттай зохион байгуулагдаж өндөрлөв.

Энэ удаагийн чуулганд Монгол улсын Зам, Тээврийн яамны харьяа Далайн захиргааны зүгээс “COAL MONGOLIA-2015” нүүрсний салбарт хөрөнгө оруулагчдын олон улсын чуулганд “2015 онд дотоодын төмөр зам болон далайн тээвэрээр дамжуулан нүүрсийг гуравдагч орон уруу гаргах боломжийн талаар” баримтлаж буй бодлогыг нүүрсний салбарын гадаад, дотоодын хөрөнгө оруулагчид болон төлөөлөгч нарт голлох сонирхолтой шинэлэг илтгэлийг тавьж оролцсон Coal Mongolia чуулганы зохион байгуулагчдын зүгээс маш их талархаж байгаагаар илэрхийлэхэд таатай байна.

2016 оны “Coal Mongolia” чуулганд бидэнтэй хамтран ажиллана гэдэгт гүнээ найдаж байна. Хувиар Зам тээврийн яамны харьяа Монгол Улсын Далайн захиргааны дарга Х.Энхбаатарт хүргүүлсэн болно.

Хүндэтгэсэн:

 Б.Алтаншагай
 УЛААНБААТАР ХОТ
 Зохион байгуулагч Хорооны дарга

Монгол Улсын Засгийн Газрын дэмжлэгтэйгээр 2015 оны 4-р сарын 9-10-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “COAL MONGOLIA-2015” Олон улсын чуулга уулзалт, үзэсгэлэнд Далайн захиргааны дарга “Монгол Улс, БНХАУ-ын далайн боомтоор далайд гарах боломж” сэдвээр илтгэл тавьж оролцсон.



Монгол Улсын экспорт, импорт, транзит бараа бүтээгдэхүүнийг далайгаар дамжуулан тээвэрлэхэд тулгардаг нийтлэг бэрхшээлийг судлах, аж ахуйн нэгж, байгууллагын төлөөлөлтэй уулзалт, семинар зохион байгуулах ажлын хүрээнд “Монголиан майнинг” корпорэйшн болон “Энержи Ресурс” ХХК-ийн холбогдох удирдлагуудтай уулзалт зохион байгуулсан.





Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн Мод тарих үндэсний өдөр зарлах тухай 63 дугаар шийдвэрийн дагуу 2015 оны 05 дугаар сарын 09-ний өдөр Зам, тээврийн яам болон Далайн захиргаа хамтран 3-н төрлийн 100 гаруй мод тарьж ургуулсан.





МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ТОГТООЛ

2015 оны 5 дугаар
сарын 11-ний өдөр

Дугаар 180

Улаанбаатар
хот

Далайн тээврийн хамтарсан
компани байгуулах тухай

Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Далай ашиглах тухай хуулийн 6.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 6-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Бүгд Найрамдах Солонгос Улсын талаас сонгон шалгаруулсан далайн тээврийн компанитай хамтран далайн тээвэр хийх хуулийн этгээд байгуулах тухай Зам, тээврийн яамны саналыг зүйтэй гэж үзсүгэй.

2. Далайн тээврийн хамтарсан хуулийн этгээдийг байгуулж, үйл ажиллагааг эхлүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Зам, тээврийн сайд Н.Төмөрхүү болон Төрийн өмчийн хороонд зөвшөөрсүгэй.

Монгол Улсын Ерөнхий сайд

Ч.САЙХАНБИЛЭГ

Зам, тээврийн сайд

Н.ТӨМӨРХҮҮ

Засгийн газрын 26 дугаар хуралдаанаар Зам тээврийн яамны харьяа Далайн захиргаа болон Бүгд Найрамдах Солонгос Улсын далайн тээврийн компанийн хөрөнгө оруулалттай Бүгд Найрамдах Солонгос Улсад бүртгэлтэй далайн тээврийн хамтарсан компани байгуулахыг 2015 оны 05 дугаар сарын 11-ний өдөр Зам, тээврийн сайд Н.Төмөрхүү болон Төрийн өмчийн хороонд зөвшөөрөв.





Далайд гарцгүй хөгжиж буй орнуудын Олон улсын судалгааны төв, НҮБ-ын Ази, номхон далайн бүс нутгийн Нийгэм, эдийн засгийн комисстой хамтран Улаанбаатар хотноо 2015 оны 5 дугаар сарын 14,15-ны өдрүүдэд зохион байгуулсан “Гамшгийг даван туулахад мэдээллийн технологийн хэрэгслийг ашиглах нь” сэдэвт хэлэлцүүлэгт Тайланд, Австрали, Бангладеш, Балба, Камбожи, Хятад, Герман, Энэтхэг, Кыргыз, Лаос, Мянмар, Пакистан, Филиппин, Шри-Ланк улсын холбогдох мэргэжилтнүүд, Монгол улсын мэдээлэл, харилцаа холбооны салбарын төр, хувийн хэвшлийн төлөөлөгчид болон Зам, тээврийн яамны харьяа Далайн захиргаанаас ахлах мэргэжилтэн Д.Байгалмаа оролцсон.

УБТЗ-ын Тээврийн дээд сургуулийн Далайн тээврийн мэргэжлийн 1, 2-р курсын оюутнууд хамтран “Солонгосын соёлын өдөрлөг”-ийг 2015 оны 5 дугаар сар 20-ны өдөр зохион байгуулсан.



Тус өдөрлөгт ЗТЯ-ны Далай ашиглалт, усан замын тээврийн хэлтсийн дарга Р.Мэргэн, ахлах мэргэжилтэн Б.Мөнхболд, Далайн захиргааны дарга Х.Энхбаатар, мэргэжилтэн С.Наранцэцэг нар урилгаар оролцсон.

"Усан замын тээврийн хэрэгсэлд техникийн болон экологийн хяналтын үзлэг хийх, тоо бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам" шинэчлэгдсэнтэй холбогдуулан нийт усан замын тээврийн хэрэгслээр үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллага, иргэд, эзэмшигчдэд 2015 оны 05 дугаар сараас эхлэн Далайн захиргаанаас олгох болсныг олон нийтэд хэвлэл мэдээллийн хэрэгслээр танилцуулсан.




БНХАУ-ийн Шандунь мужийн “Рижоу боомт групп”-ын Дэд ерөнхийлөгч Жан Дун Шен тэргүүтэй төлөөлөгчид Далайн захиргааны урилгаар манай улсад 2015 оны 5 дугаар сарын 25-аас 30-ны өдрүүдэд уригдан ЗТЯ-ны Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Ч.Цогтбаяр, Далай ашиглалт, усан замын тээврийн хэлтсийн дарга Р.Мэргэн, Далайн захиргааны дарга Х.Энхбаатар нар хүлээн авч уулзсан.



Айлчлалын хугацаанд төлөөлөгчид Монголын уул уурхай, тээвэр жууч, төмөрлөгийн үйлдвэрийн томоохон аж ахуй нэгжүүд болох “Энержи ресурс” ХХК, “Туушин” ХХК, “Болдтөмөр Ерөө гол” ХХК зэрэг компаниудтай уулзах уулзалтыг Далайн захиргаа зохион байгуулж, хоёр орны хувийн хэвшлүүдийн хоорондын харилцаа, хамтын ажиллагааг дэмжихэд чухал үүрэг гүйцэтгэсэн.



Монгол Улсын Далайн захиргаа, БНСУ-ын “Саммок шиппинг” ХХК-тай хамтарсан далайн тээврийн компани байгуулах асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэж шийдвэрлэсэнтэй холбогдуулан “Шарын гол” ХК-ийн хүсэлтийн дагуу холбогдох төлөөлтэй уулзалт зохион байгуулсан ба цаашид далайн тээврийн хамтарсан компанитай туршилтын тээвэрлэлтээр хамтран ажиллах сонирхолтой байгааг илэрхийлсэн.



Далайн захиргаа нь "Онцгой байдлын ерөнхий газар"-тай Монгол Улсын гол, мөрөн, нууранд усан замын тээврийн хэрэгслээс хүний амь нас, эрүүл мэнд эрсдэхээс урьдчилан сэргийлэх хяналтын үйл ажиллагааг сайжруулахад хамтран ажиллах, мөн төрийн байгууллагын уялдаа холбоо, хамтын ажиллагааг шинэ түвшинд гаргах зорилгоор 2015 оны 06 дугаар сарын 12-ны өдөр санамж бичиг байгуулсан.



**ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР,
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМНЫ ХАРЬГА ДАЛАЙН ЗАХИРГАА
ХООРОНД ХАМТРАН АЖИЛЛАХ САНАМЖ БИЧИГ**

2015 оны ... сар ... өдөр Дугаар... Улаанбаатар хот

Гамшгаас хамгаалах тухай, Байгаль орчныг хамгаалах тухай, Усан замын тээврийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, төрийн байгууллага хоорондын хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор нэг талаас Онцгой байдлын ерөнхий газар, нөгөө талаас Далайн захиргаа /хамтад нь цаашид "Талууд" гэх/-ны хооронд харилцан тохиролцож энэхүү "Санамж бичиг"-ийг байгуулав.

НЭГ, НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү санамж бичгийн зорилго нь усан замын тээврийн хэрэгслээс ослоход, ослын улмаас хүний амь нас, эрүүл мэнд, Байгаль орчинд хор хөнөөл учрахаас урьдчилан сэргийлэх, эрэн хайх, аврах үйл ажиллагааг шуурхай зохион байгуулах, усан замын тээврийн хэрэгслийн аюулгүй байдлыг хангах, сургалт, сурталчилгаа зохион байгуулах чиглэлээр хамтран ажиллахад оршино.

1.2. Талууд хамтын ажиллагаандаа Монгол Улсын хууль тогтоомжийг дагдан, байгууллага хоорондын харилцааны зохицот хэмжээг баримтлах, харилцан санал солилцох, зөвшилцөх, эрх тэгш байдлыг эрхэмлэх, нээлттэй ил тод байдлыг хангах, үр бүтээлтэй хамтран ажиллах зарчмыг баримтлана.

ХОЁР, ТАЛУУДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА

2.1. Усан замын тээврийн хэрэгсэл ашиглан үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн тээврийн хэрэгслийн аюулгүй байдал, тээвэрлэлтийн үйл ажиллагаанд кинхалт тавих, гол мөрөн, нуур, цөвөрчид усан замын тээвэрээс үүдэх болон бусад аюул, ослоос урьдчилан сэргийлэх, эрэн хайх, аврах ажиллагааг зохион байгуулах;

2.2. Усан замын тээврийн хэрэгсэл ашиглан үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд болзошгүй аюул, ослоос урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэхэд нь мэргэжлй арга зүйн дэмжлэг үзүүлэх, сургалт сурталчилгаа зохион байгуулах;

2015 оны 06 дугаар сарын 19-ний өдөр Их Тэнгэр цогцолборт нээлтээ хийсэн "Бизнесийн дээд хэмжээний уулзалт-2015" хуралдааны үеэр далайн тээврийн "Монгол Саммок Ложистикс" ХХК болон "Шарын гол" ХК хамтран ажиллах туршилтын тээвэр хийх санамж бичигт гарын үсэг зурсан. Энэхүү арга хэмжээний үеэр Монгол Улсын ерөнхийлөгч Цахиагийн Элбэгдорж далайн тээврийн хамтарсан компани болох "Монгол Саммок Ложистикс" ХХК болон "Шарын гол" ХК-ны цаашдын хамтын ажиллагаанд амжилт хүссэн.



Усан замын тээврийн тухай хууль, дүрэм, журам болон бага оврын усан онгоц, завь, катерыг хэрхэн осол, аюулгүй жолоодох, аврах хантаазны стандарт, түүний ашиглалт, төрөл ангилал зэрэг аюулгүй ажиллагааны зааварчилгаа, хамтарсан сургалт зөвлөгөөнийг энэ оны 07 дугаар сарын 1, 2-ны өдрүүдэд ЗТЯ, Хөвсгөл нуур Эгийн голын сав газрын захиргаа, Хөвсгөлийн улсын тусгай хамгаалалттай газрын захиргаа зэрэг орон нутгийн төрийн байгууллагуудтай хамтран зохион байгуулсан. Сургалт, зөвлөгөөнд нийт 166 иргэн хамрагдсан байна.



Олон Улсын Далайн байгууллагаас зохион байгуулагддаг ээлжит Бүс нутгийн семинар нь ISPS code буюу Олон улсын хөлөг онгоцны болон боомтын аюулгүй байдлын дүрэм мөн далайн аюулгүй байдлын сургалтаар 2015 оны 07 дугаар сарын 25-31-ний хооронд Малайз Улсын Жохор Бару хотод зохион байгуулагдсан. Тус семинар буюу сургалтад нийт 16 орны 34 төлөөлөгчид оролцсоноос Монгол Улсын Далайн захиргааны ахлах мэргэжилтэн Д.Байгалмаа, мэргэжилтэн Г.Золбоо нар амжилттай оролцон гэрчилгээ сертификатаа гардан авсан.



IMO REGIONAL SEMINAR

ON ISPS CODE TRAINING AND MARITIME SECURITY, JOHOR BAHRU, JOHOR
27 - 31 JULY 2015



2015 оны 08 дугаар сарын 19-21-ний өдрүүдэд Сингапур Улсад Далайн аюулгүй байдлын чуулга уулзалт болж Далайн захиргааны ахлах мэргэжилтэн Д.Байгалмаа болон Сингапур Улс дахь Монголын хөлөг онгоцны бүртгэл ХХК-ийн Засгийн газрын итгэмжлэгдсэн төлөөлөгч Б.Бүрэнжаргал нар оролцож Сингапур Улсын боомтод ажиллав. Далайн аюулгүй байдлын чуулга уулзалтанд АНУ, Их британи, Сингапур, Малайз, Индонез, Хятад зэрэг орны аврах үйл ажиллагааг гардаж явуулдаг төрийн болон төрийн бус байгууллага, холбоо, аж ахуйн нэгж мөн тэдгээрт тоног төхөөрөмж нийлүүлдэг бизнесийн байгууллагуудын төлөөлөл оролцсон юм.





БНСУ-ын KOICA Олон улсын байгууллагаас Далайн салбарт тэргүүлэгч орны нэг БНСУ-ын далайн тээвэр болон боомтын үйл ажиллагаанд шинээр нэвтрүүлж буй техник технологийг хөгжиж буй орнуудад танилцуулах зорилгоор 2015 оны 08 дугаар сарын 30-наас 09 дүгээр сарын 17-ныг хүртэл зохион байгуулагдсан “Далайн тээвэр болон боомтын хөгжил” сэдэвт сургалт, семинарт Далайн захиргааны мэргэжилтэн, Монголын эмэгтэй далайчдын нэг С.Наранцэцэг Монгол Улсын далайн салбарын өнөөгийн байдлын талаар танилцуулж тус семинарт амжилттай оролцоо.





Олон Улсын Далайн Байгууллага, Филиппин улсын Далайн захиргаа, Филиппин улсын Далайн тээвэр, загас агнуурын яам хамтран 2015 оны 09 дүгээр сарын 21-25-ны өдрүүдэд “Дотоодын усан замын тээврийн аюулгүй ажиллагаанд оролцох эмэгтэйчүүдийн нөлөөлөл” сэдэвт Азийн бүс нутгийн чуулга уулзалтанд Азийн 20 гаруй орны Далайн тээврийн салбарын эмэгтэй төлөөлөл оролцсон юм. Тус чуулга уулалтаар Далайн захиргааны мэргэжилтэн Ш.Долгион Монгол Улсын дотоодын усан замын тээврийн салбарын бодлого, тогтолцоо, үйл ажиллагаа, тулгамдаж буй асуудлын талаар танилцуулж, амжилттай оролцсон.



“25-р суваг” телевизээс санаачлан хэрэгжүүлж буй “1000 төгрөг төсөл” Түлэнхийн нөхөн сэргээх тасагт арьс зүсэгч автомат төхөөрөмж, дагалдах хэрэгслийг авч өгөх, Олон мянган бяцхан үрсийн амьдралд аз жаргал, гэрэл гэгээ бэлэглэх энэхүү сайн үйлсийн аянд Далайн захиргааны хамт олон нэгдэж мөн хүн бүр нэгдэхийг уриалж оролцсон.

Оросын Холбооны Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамны Онц бөгөөд Бүрэн Эрхт Элчин Сайдын эдийн засгийн асуудал хариуцсан зөвлөх Дагбаин Балта Балдановичтай Далайн захиргааны ахлах мэргэжилтэн Д.Байгалмаа, мэргэжилтэн Г.Золбоо нар 10 дугаар сарын 23-ны өдөр уулзалт зохион байгуулж Монгол Улс, ОХУ-тай усан замын тээврийн үйл ажиллагааг хамтран зохион байгуулж усан замын тээврийн хэрэгслээр Сэлэнгэ, Орхон мөрнөөр тээвэр эрхлэх ажилд тусламж дэмжлэг үзүүлж хамтран ажиллах талаар хүсэлт тавьсан.



БНСУ-ын Сүүл хотноо 2015 оны 11 дүгээр сарын 2-оос 6-ны хооронд зохион байгуулагдсан “Дэлхийн авто замын 25 дугаар Их Хурал”-д Монгол Улсын Зам, тээврийн дэд сайд Х.Ержан, БНСУ-ын Далайн хэрэг, загас агнуурын яамны дэд сайд Юн Хаг Бэ-тэй 11 дүгээр сарын 4-ний өдөр албан ёсны уулзалтыг зохион байгуулж, хоёр орны Далайн тээвэр болон логистикийн салбарын хамтын ажиллагааг өргөжүүлэх, Монгол-Солонгосын хамтарсан далайн тээврийн “Монгол Саммок Ложистикс” ХХК-ийн үйл ажиллагааг идэвхижүүлэн ажиллах, мөн Монгол далайчдыг тус улсад далайн тээврийн мэргэжлээр суралцуулж байгаад талархлаа илэрхийлээд цаашид их далайд гарч ажиллахад дэмжлэг үзүүлэхийг хүссэн юм.





Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын нийслэл Лондон хотод 2015 оны 11 дүгээр сарын 23-аас 12 дугаар сарын 2-ны өдрүүдэд Олон Улсын Далайн байгууллагын Ассемблейн 29-р ээлжит чуулган зохион байгуулагдсан.

Чуулганы үеэр Бүгд Найрамдах Панам Улсын Далайн хэргийн сайд Ноён Жорж Баракат Питти болон Далайн захиргааны удирдлагуудтай мөн Сэнт-Кристофер ба Невис улсын ОУДБ-ын байнгын төлөөлөгч, тус улсын хөлөг онгоцны бүртгэлийн компанийн бүртгэгч ноён Нигэл Е Смитт нартай уулзаж хөлөг онгоцны бүртгэлийн компанийн үйл ажиллагаатай танилцаж далайн салбарт хамтран ажиллах тал дээр санал солилцох, хөлөг онгоцны бүртгэлийн компанийн үйл ажиллагааны чиглэлээр харилцан туршлага солилцох хүсэлт тавьсан.





2015 оны 12 дугаар сарын 3-ны өдөр БНСУ-ын Бусан хотноо Зүүн Хойд Азийн дэд бүтэц, тээврийн салбарын дээд хэмжээний хурал зохион байгуулагдсан бөгөөд Зүүн Хойд Азийн бүсийн дэд бүтэц, тээврийн салбарын асуудал хариуцсан төрийн байгууллага, боомтын захиргаа, хот мужийн захиргаа, судалгаа - эрдэм шинжилгээний хүрээлэн, тээвэр зуучийн компани зэрэг байгууллагын удирдах түвшиний нийт 150 орчим төлөөлөгчдийг урьж, оролцуулсан салбарын дээд түвшний хурал болж өндөрлөлөө.

Монгол Улсын төмөр зам, далайн тээврийн дэд бүтцийн хөгжлийн хэтийн төлөв, ОХУ болон БНХАУ-аар дамжин өнгөрөх транзит тээврийн хүндрэл бэрхшээл, шийдвэрлэх арга зам, мөн салбарын боловсролын бодлогын талаар ЗТЯ-ны Төмөр зам, далайн тээврийн хэлтсийн Ахлах мэргэжилтэн Б.Мөнхболд, Далайн захиргааны Орлогч дарга Г.Цогоо, УБТЗ-ын Тээврийн дээд сургуулийн Захирал П.Нямсүрэн нар илтгэл тавьсан бол олон улсын тээвэр зуучийн үндэсний томоохон аж ахуйн нэгжийн удирдлагууд төлөөлөгчөөр оролцсон юм.



БНСУ-ын Далайн хэрэг, Загас агнуурын дэд сайд Юн Хак Бэ 2015 оны 12 дугаар сарын 14-өөс 17-ны өдрүүдэд Монгол Улсад албаны айлчлал хийж байгаа бөгөөд хөтөлбөрийн дагуу 12 дугаар сарын 15-ны өдөр УБТЗ-ын Тээврийн дээд сургуульд зочилсон. УБТЗ-ын Тээврийн дээд сургуулийн Захирал П.Нямсүрэн ноён Юн Хак Бэг хүлээн авч уулзан өөрийн сургуулийн сургалтын хөтөлбөрийн талаар товч танилцуулсан. Уулзалтад БНСУ-ын Далайн тээвэр, загас ан агнуурийн институтийг төгссөн Монгол далайчид УБТЗ-ын тээврийн дээд сургуульд Далайн тээврийн чиглэлээр суралцаж байгаа оюутнууд болон оролцсон.



Монгол Улсын Далайн захиргаа, БНСУ-ын Далайн тээвэр, Загас агнуурын институттэй байгуулсан хамтын ажиллагааны санамж бичгийн хүрээнд БНСУ-ын Далайн тээвэр, Загас агнуурын институтийг эхний 4 залуус сурч төгссөний дараа Х.Баярбат, Б.Далайбаяр нар нь 2 дахь ээлжийн элсэлтийн шалгалтанд тэнцэн, суралцаж онолын хичээлийг 6 сар үзэж, шалгалтандаа тэнцэн тус сургуулийн хөлөг онгоцтой танилцах дадлагыг 3 сарын хугацаанд сургуулийнхаа хөлөг онгоцон дээр хийж дуусгаад эх орондоо ирээд байна. Удахгүй далайчид маань гадаад их далайд 9 сарын турш хөлөг онгоцон дээр дадлага хийхээр мордоно.



ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ



ДАЛАЙН ЗАХИРГАА

Анхаарал хандуулсан таньд
баярлалаа

2015 он